ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Дорнод аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/158/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2025 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК<br>Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг<br>Утас: 88883776 Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.27 № 235

танай 2025.01.22-ны № 30 -т

ДОРНОД АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА А.ГАНТУЛГА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Сахилгын шийтгэлтэй ажилтанд тушаалын дагуу суутгалыг хийгээгүй зөрчил хүний нөөцийн аудитаар илэрч байсан бөгөөд тайлант жилд сахилгын шийтгэлтэй ажилтанд урамшуулал олгосон зөрчлийг давтан гаргасан байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022041

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Байгаль орчны газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилго, 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг даргаас 86.0 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **24,885,795.00** | **48,050,325.00** |
| **33** | **АВЛАГА** | - | 3,417,650.00 |
| **335** | **Бусад авлага** | - | 3,417,650.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 3,417,650.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 24,885,795.00 | 44,632,675.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 7,084,410.00 | 26,291,290.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 7,084,410.00 | 26,291,290.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 17,801,385.00 | 18,341,385.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 170,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 17,201,385.00 | 17,201,385.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 370,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 600,000.00 | 600,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **130,607,700.91** | **139,747,643.31** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 130,607,700.91 | 139,747,643.31 |
| **392** | **Биет хөрөнгө** | 130,607,700.91 | 139,747,643.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (3,624,999.42) | (3,874,999.38) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 125,570,073.00 | 133,270,073.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (61,632,106.49) | (77,043,785.35) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 72,026,190.00 | 101,273,790.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (35,598,017.51) | (46,282,844.02) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,929,641.97 | 14,461,323.97 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,158,534.80) | (5,753,641.83) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 56,763,636.00 | 56,763,636.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (30,668,181.84) | (38,065,909.08) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 22,800,000.00 | 22,800,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (22,800,000.00) | (22,800,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **155,493,495.91** | **187,797,968.31** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **155,493,495.91** | **187,797,968.31** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 155,493,495.91 | 187,797,968.31 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 65,759,520.00 | 65,759,520.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 65,759,520.00 | 65,759,520.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 89,693,311.91 | 121,997,784.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 89,693,311.91 | 89,693,311.91 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 32,304,472.40 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 40,664.00 | 40,664.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **155,493,495.91** | **187,797,968.31** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,525,667,867.19** | **2,533,784,164.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **25,186,660.19** | **53,243,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 25,186,660.19 | 53,243,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 25,186,660.19 | 52,265,040.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,550,000.00 | 2,514,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | 3,611,160.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 23,636,660.19 | 46,139,880.00 |
| 120009 | Бусад орлого | - | 977,960.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,500,481,207.00** | **2,480,541,164.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 59,026,407.00 | 76,154,564.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,700,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 51,528,657.00 | 58,249,604.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,797,750.00 | 17,904,960.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 2,441,454,800.00 | 2,404,386,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 2,441,454,800.00 | 2,404,386,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,526,073,586.95** | **2,501,479,691.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,526,073,586.95** | **2,501,479,691.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,082,309,032.67 | 2,236,732,438.42 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 708,410,084.72 | 1,043,365,511.06 |
| 210101 | Үндсэн цалин | 400,578,995.10 | 511,249,098.98 |
| 210102 | Нэмэгдэл | 260,751,965.23 | 476,445,372.83 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,864,176.31 | 16,000,000.00 |
| 210104 | Урамшуулал | 34,214,948.08 | 39,671,039.25 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 91,043,218.50 | 128,741,566.76 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,133,464.27 | 88,617,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,599,855.74 | 8,847,666.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,508,043.26 | 4,843,596.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,456,599.90 | 5,582,003.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,345,255.33 | 20,851,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 239,386.00 | 262,240.00 |
| 210302 | Түлш, халаалт | 239,386.00 | 262,240.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,953,090.00 | 13,208,010.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,812,671.00 | 711,710.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,340,379.00 | 11,656,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 800,040.00 | 840,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,360,900.00 | 4,330,550.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 178,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,360,900.00 | 4,152,350.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,170,000.00 | 7,800,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,170,000.00 | 7,800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,712,736.00 | 769,310.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 234,996.00 | 234,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 164,940.00 | 141,860.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 708,000.00 | 360,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,252,419,617.45 | 1,038,255,250.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,222,505,337.50 | 1,003,915,911.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,914,279.95 | 34,339,339.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 443,764,554.28 | 264,747,253.18 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 137,500,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 137,500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 443,764,554.28 | 127,247,253.18 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 443,764,554.28 | 127,247,253.18 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(405,719.76)** | **32,304,472.40** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(405,719.76)** | **32,304,472.40** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,502,031,207.00** | **2,487,644,284.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,550,000.00** | **7,103,120.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,550,000.00 | 7,103,120.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,550,000.00 | 6,125,160.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,550,000.00 | 2,514,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | 3,611,160.00 |
| 120009 | Бусад орлого | - | 977,960.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,500,481,207.00** | **2,480,541,164.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 59,026,407.00 | 76,154,564.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,700,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 51,528,657.00 | 58,249,604.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,797,750.00 | 17,904,960.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 2,441,454,800.00 | 2,404,386,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 2,441,454,800.00 | 2,404,386,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,502,031,207.00** | **2,487,644,284.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,502,031,207.00** | **2,487,644,284.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,058,266,652.72** | **2,222,897,030.82** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 708,410,084.72 | 1,041,787,577.82 |
| 210101 | Үндсэн цалин | 400,578,995.10 | 520,902,817.03 |
| 210102 | Нэмэгдэл | 260,751,965.23 | 465,213,721.54 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,864,176.31 | 16,000,000.00 |
| 210104 | Урамшуулал | 34,214,948.08 | 39,671,039.25 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 91,043,218.50 | 130,319,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,871,164.27 | 88,617,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,544,599.00 | 10,425,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,825,600.00 | 5,212,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,456,600.00 | 5,212,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,345,255.23 | 20,851,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 239,386.00 | 262,240.00 |
| 210302 | Түлш, халаалт | 239,386.00 | 262,240.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,953,090.00 | 12,711,710.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,812,671.00 | 711,710.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,340,379.00 | 11,160,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 800,040.00 | 840,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,257,900.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,257,900.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,360,900.00 | 17,031,682.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 3,500,000.00 |
| 210602 | Тавилга | - | 5,531,682.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,360,900.00 | 8,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,170,000.00 | 8,160,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,170,000.00 | 8,160,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,912,736.00 | 769,310.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,200,000.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 234,996.00 | 234,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 164,940.00 | 141,860.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 708,000.00 | 360,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,219,919,337.50 | 1,011,855,011.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,219,919,337.50 | 1,011,855,011.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **443,764,554.28** | **264,747,253.18** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 137,500,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | 137,500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 443,764,554.28 | 127,247,253.18 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 443,764,554.28 | 127,247,253.18 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **65,759,520.00** | **40,664.00** | **89,693,311.91** | 155,493,495.91 |
| D01 | **2024 оны 01р сарын 01-нээрх үлдэгдэл** | **65,759,520.00** | **40,664.00** | **89,693,311.91** | 155,493,495.91 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **65,759,520.00** | **40,664.00** | **89,693,311.91** | 155,493,495.91 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 32,304,472.40 | 32,304,472.40 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **65,759,520.00** | **40,664.00** | **121,997,784.31** | 187,797,968.31 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,395,386,600.00 | 2,270,631,306.82 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,395,386,600.00 | 2,270,631,306.82 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,239,524,600.00 | 2,133,131,306.82 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,042,555,300.00 | 1,041,787,577.82 |
| 210101 | Үндсэн цалин | 540,959,400.00 | 520,902,817.03 |
| 210102 | Нэмэгдэл | 445,156,000.00 | 465,213,721.54 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,000,000.00 | 16,000,000.00 |
| 210104 | Урамшуулал | 40,439,900.00 | 39,671,039.25 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 130,319,500.00 | 130,319,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 88,617,200.00 | 88,617,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,425,600.00 | 10,425,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,212,800.00 | 5,212,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,212,800.00 | 5,212,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,851,100.00 | 20,851,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 360,000.00 | 262,240.00 |
| 210302 | Түлш, халаалт | 360,000.00 | 262,240.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,720,000.00 | 12,711,710.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 720,000.00 | 711,710.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,160,000.00 | 11,160,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 840,000.00 | 840,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,500,000.00 | 11,500,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,160,000.00 | 8,160,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,160,000.00 | 8,160,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураа** | 2,887,700.00 | 769,310.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,016,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 235,000.00 | 234,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 235,000.00 | 141,860.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 41,700.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 360,000.00 | 360,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,031,022,100.00 | 927,620,969.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,031,022,100.00 | 927,620,969.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 155,862,000.00 | 137,500,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 155,862,000.00 | 137,500,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | 137,500,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,362,000.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 137,500,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,432,985,900.00 | 2,270,331,306.82 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,294,485,900.00 | - |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,294,485,900.00 | - |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 137,500,000.00 | 2,269,631,306.82 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 137,500,000.00 | 2,269,631,306.82 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 700,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 700,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 42 | 32 |
| 620001 | Удирдах ажилтан | 2 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 36 | 27 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4 | 4 |
| 620004 | Гэрээт ажилтан | 0 | 0 |

### 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **76,154,564.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **76,154,564.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 75,476,604.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,531,682.00 |
| 210602 | Тавилга | 5,531,682.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 69,944,922.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,944,922.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **677,960.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 677,960.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 76,154,564.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 76,154,564.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 58,249,604.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 17,904,960.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5.2 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс, аудитын явцад 5.2 сая төгрөгийн алдааг залруулллаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Байрны засварт 3.4 сая төгрөгийг шилжүүлсэн боловч ажил гүйцэтгэж дуусаагүй тул авлагаар бүртгэж залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Дээд шатны байгууллагаас ирсэн 1.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зүйлсийг орлогод аваагүй байсныг залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн толилуулах батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Бараа материалын шинжтэй 0.8 сая төгрөгийн хөрөнгийг шууд зардалд бүртгэснийг залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 6.1 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс 2.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 3.2 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэв.

### 1.1 Төлбөрийн акт

1. Ахмадын санд тусдаа данс нээж орлого зардлын бүртгэл хийгдээгүй үндсэн үйл ажиллагааны батлагдсан төсвөөс 2.0 төгрөгийг зарцуулсан ба анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харьяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Сахилгын шийтгэлтэй ажилтанд 0.9 сая төгрөгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 1.2 Албан шаардлага

1. Сэг зэм устгах ажилд зарцуулагдсан зардалд дээд шатны байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй 3.2 сая төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харьяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байрны засварт 3.4 сая төгрөгийг шилжүүлсэн боловч ажил гүйцэтгэж дуусаагүй тул авлагаар бүртгэсэн. | 1 | 3,417.5 | | | | | 1 | 3,417.5 | | | | |
| Дээд шатны байгууллагаас ирсэн 1.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зүйлсийг орлогод аваагүй байсан. | 1 | 992.8 | | | | | 1 | 992.8 | | | | |
| Бараа материалын шинжтэй 0.8 сая төгрөгийн хөрөнгийг шууд зардалд бүртгэсэн | 1 | 780.0 | | | | | 1 | 780.0 | | | | |
| **Дүн** | **3** | **5,190.3** | | | | | **3** | **5,190.3** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ахмадын санд тусдаа данс нээж орлого зардлын бүртгэл хийгдээгүй үндсэн үйл ажиллагааны батлагдсан төсвөөс зарцуулсан | 1 | 2,036.7 | 1 | 2,036.7 | | | | | | | | |
| Сахилгын шийтгэлтэй ажилтанд урамшуулал олгосон | 1 | 992.0 | 1 | 992.0 | | | | | | | | |
| Сэг зэм устгах ажилд зарцуулагдсан зардалд дээд шатны байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй зардал гаргасан | 1 | 3,093.5 | | | 1 | 3,093.5 | | | | | | |
| **Дүн** | **3** | **6,122.2** | **2** | **3,028.7** | **1** | **3,093.5** | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 5 сая төгрөгөөс дээш орлогын 73.4 сая төгрөгийн 2 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй байна. | 1 | 73,415.8 | | | | | 1 | 73,415.8 |
| **Нийт дүн** | **1** | **73,415.8** | | | | | **1** | **73,415.8** |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 111/1912/5799 ДӨА-2025/158/НА-СТА-ПШ3 Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сэг зэм устгах ажилд холбогдох эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр 3,093,460.00 төгрөгийн зардал гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 42 дугаар зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "Анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.2-т "Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн батлагсдан төсвийн хүрээнд ажил гүйлгээг хийх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040477

2. Холбогдох хууль тогтоомж, журам, шийдвэрийг баримтлан ажиллахыг Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга А.Гантулга, нягтлан бодогч З.Дарьсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ